МОНГОЛ УЛС
ДАРХАН-УУЛ АЙМАГ
ЗАСАГ ДАРГА

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059, Утас: 7037-7121,
Факс: 7037-7121, Цахим шуудан: info@darkhan.gov.mn
Цахим хуудас: www.darkhan.gov.mn

2024.06.10 № 1-10/318

танай ______ -ны № ______ т

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ГИШҮҮН, СОЁЛЫН САЙД Ч.НОМИН
ТАНАА

Танд энэ өдрийн мэнд хүргэе.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Соёлын сайд болон Дархан-Уул аймгийн Засаг даргын 2024 оны хамтран ажиллах гэрээний эхний хагас жилийн хэрэгжилтийг хүргүүлж байна.

Хавсралт..........хуудастай.

Хүндэтгэсэн,

ДАРГА Б.АЗЖАРГАЛ

4574100583

ZD-2024 toot-1

Соёлын сайд, Дархан-Уул аймгийн Засаг дарга нарын
хооронд байгуулсан гэрээний нэгдүгээр хавсралт

**ТӨРИЙН ЧИГ ҮҮРГИЙГ ТӨЛӨӨЛӨН ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ДАГУУ ХЭРЭГЖҮҮЛЭХ СОЁЛ, УРЛАГИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ**

/2024 оны эхний хагас жилийн байдлаар/

2024.06.10

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин /хэрэгжилт болон тайлбар/ | Гүйцэтгэл-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Нэг. Соёлын салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, цахим шилжилтийг дэмжих чиглэлээр** | | | | | | | |
| 1.1 | **Соёлын тухай хуулийн 24.1.2** Соёлын салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх. | 45.9 | Хөнгөлөлтэй нөхцөлөөр сургасан, нийгмийн баталгаа үзүүлсэн дэмжлэгийн тоо | 79 ажилтанд 366.7 сая төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон. | Хүний нөөцийг хөгжүүлэх чиглэлээр өмнөх оны хүрсэн түвшнийг бууруулаагүй байх. Соёлын ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлсэн байна. | 1. Соёлын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайд нарын хамтарсан 2024 оны А/166, А/63, А/73 дугаар тушаалаар “Соёл, урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт”-ийг баталсан нь соёлын ажилтнуудад ур чадварын нэмэгдэл олгох эрх зүйн орчин бүрдсэн.<br>2. Төрийн албан хаагчдыг орон сууцаар хангах хөтөлбөрийн хүрээнд тус газрын Соёл, гэгээрлийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Залуучууд театрын хөгжимчдийг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар ашиглалтад орсон дахин төлөвлөлтийн орон сууцнаас байраар хангаж, ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх хүсэлтийг аймгийн Засаг даргад гаргаж, Орон нутгийн өмчийн газрын ажлын хэсгийн шийдвэрээр соёлын 1 ажилтныг эд хөрөнгийн түрээслэгчээр шалгаруулж, орон сууцны түрээсийн гэрээ байгуулсан.<br>3. МУЗГ-ын 2023 оны 185 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчийн соёлын байгууллагын соёлын ажилтанд мөнгөн тэтгэмж олгох журам"-д заасан шаардлагыг хангасан 3 байгууллагын 8 соёлын ажилтанд 76.9 сая төгрөгийн мөнгөн тэтгэмж олгох санхүүжилтийг 2024 оны төсөвт суулгаж батлуулсан. Эхний хагас | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | жилийн байдлаар 6 соёлын ажилтанд 45.9 сая төгрөг олгогдсон байна.<br>4. Аймгийн СУГ-ын 2 албан хаагчийг богино, дунд хугацааны мэргэшүүлэх багц сургалтад хамруулаад байна. Удирдлагын академийн цахим сургалтад 4 албан хаагч хамрагдсан.<br>5. Ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл шаардлагад нийцүүлэн ашиглалтгүй байгаа талбайг ажлын өрөө болгон тохижуулж албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор Барилгын тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд заасны дагуу барилга байгууламжийн ашиглалтын үеийн чанар, аюулгүй байдлын төлөвт дүгнэлт гаргуулахаар, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл байдалд эрсдэлийн үнэлгээ хийлгүүлэхээр аймгийн ГХБХБГ, ХХҮХ-т тус тус хүсэлт гаргасан.<br>6. Залуучууд театр мэргэжлийн боловсон хүчнээр хангах хүний нөөц бүрдүүлэх зорилгоор 2024.04.10-04.12-ны өдрүүдэд МУ-ын Консерваторитой хамтран тус сургуулийн Ардын бүжгийн ангийн элсэлтийн шалгалтыг зохион байгуулан ЕБС-ийн 7-р ангийн 200 гаруй сурагчид хамрагдаж 8 хүүхэд тэнцэж суралцах эрхээ авсан.<br><br>**Хүрсэн түвшин:**<br>**-**Соёл, урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт батлагдаж батлагдсан төсвийн хүрээнд санхүүжилт шийдэгдэж нийгмийн асуудал нь дээшилсэн.<br>-Төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдэж, орон нутагт ажилласны нэмэгдлийг төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагч авах эрх зүйн бүрдэж амьжиргааны түвшин дээшилсэн.<br>-Соёлын 1 ажилтан түрээсийн орон сууцаар хангагдсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -Соёлын 2 байгууллагын 6 соёлын ажилтанд 45.9 сая төгрөгийн мөнгөн тэтгэмж олгогджээ.<br>-Төрийн хөрөнгөөр 2 албан хаагчийг сургалтад хамруулсан. Удирдлагын академийн цахим сургалтад 4 албан хаагч хамрагдсан. | |
| 1.2 | **Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоол Шинэ сэргэлтийн бодлого 4.2** Соёл, урлагийн байгууллагуудад шилжин суурьшин ажиллах иргэдийг бодлогоор дэмжих. | Батлагдсан төсвийн хүрээнд | Орон нутагт шилжин суурьшихад дэмжлэг үзүүлсэн арга хэмжээний тоо /орон сууц, бусад/ | Соёлын 5 байгууллагад 7 албан хаагч шилжин ирж орон байр, ажиллах орчин нөхцлөөр хангасан. | Орон нутгийн соёлын байгууллагад хотоос шилжин суурьшиж ажиллах иргэдэд дэмжлэг үзүүлсэн байна. | 1.Залуучууд театрын ашиглалтгүй байсан өргөтгөлийн хэсгийг орон нутгийн болон байгууллагын үйл ажиллагааны зардлаас засварлаж 2 айлын түр амьдрах орон сууцыг бий болгосон. Тус байранд шинээр томилогдсон 1 найруулагч түр байрлаж байна.<br>2.Сэлэнгэ аймгаас Орхон сумын Соёлын төвийн хөгжмийн багш, хүний нөөц, Архив бичиг хэргийн албан тушаалын сул орон тоонд шилжин ирж ажиллах хүсэлт гаргасан 2 иргэнийг ажлын байраар хангаж, түр амьдрах байрыг бэлтгэсэн.<br><br>**Хүрсэн түвшин:** Соёлын 2 байгууллагад нийт 3 соёлын ажилтан шилжин ирж орон байр, ажиллах орчин нөхцөлөөр хангагдсан. | 100% |
| 1.3 | **"Алсын хараа 2050" 5.3, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.2.1** "Цахим соёл" арга хэмжээний хүрээнд хөгжүүлсэн Creativehub-ийг нэвтрүүлж, чөлөөт уран бүтээлч болон | Батлагдсан төсвийн хүрээнд | Бүртгэлд хамруулсан уран бүтээлчдийн тоо | Creativehub цахим системийн хөгжүүлэлт хийгдсэн. | 50-аас доошгүй уран бүтээлчийг бүртгэлд хамруулсан байна. | 1.Тус газраас соёлын бүтээлч үйлдвэрлэлийн 12 салбарын уран бүтээлч, ААН-үүдийг холбох, хамтран уран бүтээл туурвих боломжийг бүрдүүлсэн https://creativehub.mn/ дижитал системийг хэрхэн хөгжүүлэх тухай танхимын сургалтыг 2 удаа зохион байгуулж, соёлын байгууллагын 18 албан хаагчийг хамруулсан. Соёлын байгууллагууд системийн талаарх цахим мэдээллийг байгууллагын цахим хуудсаараа дамжуулан иргэд, олон нийтэд 6 удаа сурталчилсан. Системд тус аймгийн 8 соёлын байгууллага бүртгүүлж, Музей 3, Хүүхдийн номын ордон 2, Төв номын сан 1, Залуучууд театр 5, Шарын гол, Орхон, Хонгор сумдын соёлын төвүүд 10 буюу нийт 35 уран бүтээлч, СББӨ-ийг өвлөн уламжлагчийг бүртгэсэн байна.<br><br>**Хүрсэн түвшин:** Creativehub цахим системийн сургалтыг 2 удаа зохион байгуулж, нийт **35 уран** | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгууллагыг бүртгэхэд дэмжлэг үзүүлж хамтран ажиллах. | | | | | **бүтээлч, СББӨ-ийг өвлөн уламжлагч**ийг бүртгэсэн. | |
| 1.4 | **"Алсын хараа 2050" 5.3, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.2.1** "Цахим соёл" арга хэмжээний хүрээнд хөгжүүлсэн /номын сан, соёлын өв, GLAM, портал сайт/ системүүдийг орон нутагтаа нэвтрүүлж, хэрэгжилтийг хангах. | Батлагдсан төсвийн хүрээнд | Мэдээллийн санд бүртгэгдсэн мэдээллийн хувь | Номын сан, соёлын өв, GLAM, портал сайт цахим системийн хөгжүүлэлт хийгдсэн. | Номын сан, соёлын өв, уран бүтээлийн бүртгэл мэдээллийн санг 25 хувьд хүргэнэ. Салбарын портал сайт ашиглалтыг тогтмол, тасралтгүй хэрэгжүүлсэн байна. | 1. 2024.05.27-29-ний өдрүүдэд Соёлын яамнаас зохион байгуулсан “Соёлын салбарын мэдээллийн систем” сургалтад нийт 17 албан хаагч хамрагдаж https://cis.mn/ системийн https://cis.mn/auth хэсэгт харьяа соёлын 7 байгууллагын 2021-2023 оны үйл ажиллагааны болон санхүү хөрөнгийн статистик мэдээг маягтын дагуу бүрэн оруулж дууссан.<br>2. Монгол Улсын ҮННС-гийн “Цахим танхим”-ын нээлт, “Соёлын салбарын мэдээллийн системүүд, түүний ашиглалт” танхимын сургалтад тус аймгийн номын сангийн захирал, мэдээллийн ажилтан, номын санч нийт 3 хүн хамрагдсан.<br>3. Төв номын сан “Lib4u” программд шинээр 405 нэр төрлийн 516 боть ном, “Zotero” программд 1966 оны Найрамдлын Дархан сонины нийт 37 мэдээллийг тус тус бүртгэж, 28716 нэр төрлийн 57256 боть номын фондын электрон каталогийн цахим сан хөмрөгийг Үндэсний номын санд файлаар хүргүүлж номын сангийн цахим системд оруулах бэлтгэл ажил хийгдсэн.<br>4. What3words Limited цахим хуудасны системд аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал болон сумдын орон нутаг судлах танхимын мэдээллийг хүргүүлсэн.<br>5.Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэлийн Register программ, Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн RICH программ, Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн бүртгэлийн www.mongoluv.mn программуудын дата мэдээллийг Соёлын өвийн үндэсний төвд хүргүүлж шинэчлэл хийлгүүлэв.<br>6. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-8.5 дахь заалтын 98 мэдээллээс өөрт хамааргдах 46 заалтын мэдээллийг Дархан-Уул аймгийн Соёл, урлагийн газрын https://da.moc.gov.mn/ цахим хуудсанд | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тогтмол нийтэлж байна. Үйл ажилагааны ил тод байдлын хүрээнд 49 цэсэд 696 мэдээ, мэдээлэл нийтэлсэн.<br>7. Соёлын 7 байгууллагуудад албаны имэйл хаяг нээж, эрх өгсөн.<br>8. Төв номын сан, Музей нь “ДАНДА Солюшн” ХХК-иар цахим сайт хийлгэх гэрээ байгуулсан ба номын сангийн цахим хуудасны гүйцэтгэл 30%, музейн цахим хуудасны гүйцэтгэл 80% -тай байна.<br><br>**Хүрсэн түвшин:**<br>"Цахим соёл" арга хэмжээний хүрээнд хөгжүүлж буй номын сангийн системийг орон нутагтаа нэвтрүүлэхэд шаардлагатай дата мэдээллийг хүргүүлсэн.<br>Соёлын салбарын мэдээллийн системийн https://cis.mn/auth хэсэгт харьяа соёлын 7 байгууллагын 2021-2023 оны үйл ажиллагааны болон хөрөнгө санхүүгийн статистик мэдээг маягтын дагуу бүрэн оруулж дууссан.<br>Портал сайтыг тасралтгүй хөгжүүлж тайлант хугацаанд https://da.moc.gov.mn/ цахим хуудасны 49 цэсэд 696 мэдээ, мэдээлэл нийтэлсэн байна. Соёлын 2 байгууллага цахим хуудас хийлгэж байна. | |
| 1.5 | **Статистикийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3, 18 дугаар зүйлийн 18.1, 18.2, 19 дүгээр зүйлийн 19.3.**<br>Соёлын салбарын статистикийн мэдээ, тайланг батлагдсан маягтын дагуу өмчийн бүх хэлбэрийн соёл, урлагийн | Үйл ажиллагаа | Бүртгэлийн болон захиргааны статистикийн маягтаар гаргасан тайлангийн тоо | -2023 оны үйл ажиллагааны тайлан,<br>-Ажиллагсдын статистик 11 мэдээ<br>-Хөрөнгө, санхүүгийн мэдээ | Бүртгэлийн статистикийн 11, захиргааны статистикийн 12 маягтаар гаргасан тайлангийн тоо | -Харьяа соёлын 7 байгууллагаас 2023 оны жилийн эцсийн үйл ажиллагааны статистик мэдээг Б-бүртгэлийн 11 маягтаар авч З-захиргааны 12 маягтад нэгтгэн 2024.01.25-ны өдрийн дотор баталгаажуулан ЗГХА СУГ-т хугацаанд нь илгээсэн.<br>-СУГ болон соёлын 7 байгууллагын 2023 оны хөрөнгө, санхүүгийн статистик мэдээг СУХС маягтад нэгтгэн баталгаажуулж 2023.04.15-ны өдөр ЗГХА СУГ-т хугацаанд нь илгээсэн.<br>- 2024 оны соёлын 7 байгууллагын I, II улирлын үйл ажиллагааны статистик мэдээг хугацаанд нь гаргаж ЗГХА СУГ-т хугацаанд нь илгээсэн.<br><br>**Хүрсэн түвшин:** Тайлант хугацаанд бүртгэлийн статистикийн 11, захиргааны статистикийн 12 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгууллагуудаас цуглуулж, тогтоосон хугацаанд нь үнэн зөв, бодитой гаргаж ирүүлэх. | | | | | маягтаар соёлын 7 байгуулл агын жилийн эцсийн тайланг 1 удаа, СУХС маягтаар жилийн эцсийн тайланг 1 удаа, улирлын тайланг 2 удаа тогтоосон хугацаанд нь илгээсэн. | |
| **Хоёр. Соёлын боловсролыг дээшлүүлэх чиглэлээр** | | | | | | | |
| 2.1 | **Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.2.2** Соёлын сэргэлт–2024 арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж оролцох. | Үйл ажиллагаа | Дэмжлэг үзүүлсэн арга хэмжээний тоо, зарцуулсан төсөв | Хөдөөгийн сэргэлт, шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд “Соёлын сэргэлт- 2023” арга хэмжээ зохион байгуулсан. | Орон нутгийн оролцоог хангаж оролцсон байна.<br><br>Арга хэмжээнд дэмжлэг үзүүлж санхүүжүүлсэн байна. | 1. Соёлын сайдын 2024 оны А/74 дүгээр тушаалаар “Соёлын сэргэлт 2024” аяныг зохион байгуулах ажлын хэсгийн Төвийн бүсийн ахлагчаар тус газрын дарга ажиллахаар томилогдсон. Ажлын хэсгийн 8 удаагийн цахим хуралд оролцож аяны хүрээнд зохион байгуулах ажлын саналыг төвийн бүсийн хэмжээнд нэгтгэн авч 20 арга хэмжээ бүхий нэгдсэн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж Соёлын яамны СБХЗГ, ЗГХА-СУГ-т тус тус хүргүүлсэн. Төвийн бүсийн “Соёлын сэргэлт 2024” аян нь ирэх 09 дүгээр сард зохион байгуулагдахаар хойшлогдсон.<br>2. 2024.05.06-ны өдөр Улаабаатар хотноо зохион байгуулагдсан “Соёлын сэргэлт-2024” соёлын салбарын удирдах ажилтнуудын нэгдсэн зөвлөгөөнд тус газрын дарга, ЗУХ, СУХ-ийн дарга, Залуучууд театр, Музей, Төв номын сан, Хүүхдийн номын ордон, Шарын гол, Орхон, Хонгор сумдын Соёлын төвийн нийт 10 удирдлага оролцсон.<br><br>**Хүрсэн түвшин:** Төвийн бүсийн “Соёлын сэргэлт-2024” аяны хүрээнд зохион байгуулах 20 арга хэмжээ бүхий нэгдсэн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулсан. Ажлын хэсгийн 8 удаагийн цахим хуралд оролцож “Соёлын сэргэлт 2024” нэгдсэн зөвлөгөөнд тус аймгийн 7 байгууллагын 10 удирдлага оролцсон. | 90% |
| 2.2 | **Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйл, Монгол Улсын Засгийн газрын** | Орон нутгийн төсөв | Зохион байгуулсан арга хэмжээний тоо, | - | 20-оос доошгүй арга хэмжээ, 2-оос доошгүй нөлөөллийн аян зохион | “Бүх нийтийн соёлын боловсрол” арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 5 зорилт 34 арга хэмжээний 2024 оны эхний хагас жилийн биелэлтийн тайланг 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 01/173 тоот албан бичгээр Соёлын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.2.2** Бүх нийтийн соёлын боловсрол арга хэмжээний төлөвлөгөө, “Нийгмийн харилцааны соёлыг дээшлүүлэх нөлөөллийн цогц ажлуудыг зохион байгуулах” тухай сайд нарын хамтарсан албан даалгаврын хэрэгжилтийг хангах. | | нөлөөллийн аяны тоо | | байгуулсан байна. | яамны Соёлын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт хүргүүлсэн. ***/Хавсралт 1/***<br><br>**Хүрсэн түвшин:**<br>- Соёлын 7 байгууллагууд соёлын боловсролын 28 хөтөлбөрийг 95 удаа зохион байгуулж 5868 хүн, 24 дугуйланд 790 хүүхэд хамрагдсан.<br>- Залуучууд театр нь урлагийн 28 тоглолтыг 9550 үзэгчдэд, Шарын гол сумын Соёлын төв 13 тоглолтыг 5478 үзэгчдэд, Орхон сумын Соёлын төв 3 тоглолтыг 1604, Хонгор сумын соёлын төв 3 тоглолтыг 618 иргэдэд толилуууллаа.<br>- Соёлын 7 байгууллага нийт 13 үзэсгэлэнг дэглэж 11190 гаруй үзэгчдэд хүргэлээ.<br>- Цахимаар нөлөөллийн 8 аянд нэгдэж 10 арга хэмжээ зохион байгуулж нийт 100 гаруй мэдээ бэлтгэсэн.<br>- Тус газраас зохион байгуулсан “Шугаман бүжгийн тэмцээн”-д 19 байгууллагын 192 албан хаагч оролцсон.<br>- Залуучууд театр “Тайзны урлаг” сурталчлах өдөрлөг зохион байгуулж 300 хүүхэд хамрагдлаа.<br>- Музейн танхимаар 4, нүүдлийн 3, нийт 7 үзэсгэлэн зохион байгуулж 9817 үзэгчдийг хамруулсан байна.<br>- Аймгийн хэмжээнд номын сангаар ном олголт 47903, уншигч 4720, иргэсэд 37672 үйлчлүүлсэн.<br>- Шарын гол, Орхон, Хонгор сумдын Музейгээр нийт 3867 иргэн үйлчлүүлсэн байна. | |
| 2.3 | **Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний** | Үйл ажиллагаа | Дэмжлэг үзүүлсэн арга хэмжээний тоо Үзэгчдийн тоо | Үзэгчдийн тоо-600 | 2-оос доошгүй арга хэмжээнд дэмжлэг үзүүлнэ. Үзэгчдийн тоог -2100 | 1. Шарын гол, Орхон, Хонгор сумдын Соёлын төв нь “Т-энтэртайнмент” ХХК-тай гэрээ байгуулж 2024 оны хагас жилийн байдлаар Мануухай, Зүрх зүсэм, Бидний араншин, Кикоро, Миний муу найз, Сургуулийн хайрын түүх, Улаан явар нийт **7** киног 280 үзэгчдэд толилуулсан байна. Нийт 1,221,000 төгрөгийн орлого төвлөрүүлж гэрээний дагуу 550000 төгрөгийг тус компанид шилжүүлсэн.<br><br>2. Дээрх сумдын Соёлын төвүүд нь бусад байгууллагын Fearbook, Улаан явар, Зэтгэр, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **төлөвлөгөөний 2.6.2.2** Соёлын төвүүдэд түүхэн сэдэвт болон хүүхэд, залуучуудад зориулсан кино гаргаж, кино урлагаар дамжуулан соёлын боловсрол олгох арга хэмжээг дэмжих. | | | | | Сүнсний стори, Зура, Зүүдний кафе, Цуст гринч, Сургуулийн сүнс зэрэг нийт **8** киног 1424 үзэгчдэд хүргэж 1,750,600 төгрөгийн орлого олсон байна.<br><br>**Хүрсэн түвшин:** Нийт **15 киног** 1704 үзэгчдэд хүргэж 2,971,600 төгрөгийн орлого олсон байна. | |
| 2.4 | **Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.2.2** Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй хүүхдийн зусланд нүүдлийн ахуй соёл, уламжлалыг таниулах үйл ажиллагаа зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх. | Орон нутгийн төсөв 20,0сая | Дэмжлэг үзүүлсэн арга хэмжээний тоо | Дэмжлэг үзүүлсэн арга хэмжээ-2 | 2-оос доошгүй арга хэмжээнд дэмжлэг үзүүлсэн байна. | 1. Үндэсний хэмжээнд хэрэгжиж буй Нүүдлийн соёлын боловсролын зуны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Дэлхийн мөрөөдлийн сургууль ТББ-тай Дархан сумын Засаг дарга Хамтын ажиллагааны санамж бичгийг 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр байгуулсан. Тус санамж бичгийн хүрээнд тус аймгийн Хонгор сумын газар нутаг болох Зурамтайн хөндийн 6 га газарт Дархан хотын Нүүдлийн соёлын зусланг байгуулахаар тусгасан. Тус хөтөлбөрт Дархан сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 20,0 сая төгрөгийн санхүүжилтээр иж бүрэн 5 ханатай гэр-5ш, гэр тус бүр 5 ор буюу нийт 25 ширхэг орыг хүлээлгэн өглөө. Нүүдлийн соёлын зуслан 2024 оны 06 дугаар сарын 17-ны өдрөөс нийт 9 ээлж ажиллана. Эхний ээлж 25 хүүхэдтэйгээр үйл ажиллагаагаа эхлүүлнэ.<br><br>2. “Зулзага” хүүхдийн зусланд амрагч хүүхдүүдэд соёлын өв, нүүдлийн ахуй соёл, уламжлалыг таниулах зорилгоор соёлын 5 байгууллагын 13 соёлын боловсролын хөтөлбөрийг нэгтгэн аймгийн Гэр бүл, хүүхдийн хөгжил хамгааллын газарт хүргүүлсэн. Тус соёлын боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд аймгийн ЗДТГ-ын НБХ-ээс 5 ханатай Монгол гэрийг шийдвэрлэсэн. Соёлын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | боловсролын хөтөлбөрийг 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн нийт 7 ээлжинд хэрэгжүүлнэ.<br><br>**Хүрсэн түвшин:** Хүүхдүүдэд зориулж зохион байгуулах нүүдлийн ахуй соёл, уламжлалыг таниулах хөтөлбөр бүхий **2 зуслангийн** үйл ажиллагааг 7 ээлжинд зохион байгуулахад дэмжлэг үзүүлж ажилласан. | |
| 2.5 | **Соёлын тухай хуулийн 9.1.4, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны бодлогын Зорилт 1.4.** Түүх, соёл, утга зохиол судлалын орон нутгийн судлаач, зохиолчдыг дэмжих. | Орон нутгийн төсөв 6,265,000 төгрөг | Зохион байгуулсан арга хэмжээний тоо, дэмжлэг үзүүлсэн арга хэмжээний тоо | Зохион байгуулсан арга хэмжээ-3 Дэмжлэг үзүүлсэн арга хэмжээ-1 | 3-аас доошгүй арга хэмжээ зохион байгуулж, дэмжлэг үзүүлсэн байна. | 1. “Дарханы түүх, соёл, эрт эдүгээ” эрдэм шинжилгээний хурлыг 2024.04.12-ны өдөр зохион байгуулж, 120 хүнийг хамруулсан. Тус хуралд 14 эрдэмтэн, академич, доктор, профессор, судлаачид оролцож бүтээн байгуулалтын үеийн Дархан хот, археологийн судалгааны үр дүн, түүх, соёлын архивын баримтууд, угсаатны зүйн судалгаа, Музейн үзэл баримтлал зэрэг сэдвээр илтгэл тавьж хэлэлцүүлэв. Бага хурлыг зохион байгуулах зардалд аймгийн ЗДТГ-ын даргын 2024 оны 02-А/58 дугаар захирамжаар 2.0 сая төгрөг, Дархан сумын ЗДТГ-аас 2.0 сая төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсэн.<br>2. “Монгол гэр” үзэсгэлэнгийн хүрээнд зарласан эрдэм шинжилгээний хуралд Дархан нутаг судлаач, Дэд профессор Музейн захирал Д.Жамбалдорж “Монгол гэрийн үүсэл хөгжил” сэдвээр илтгэл хэлэлцүүллээ.<br>3. “Хос бичигтэн-2025” эрдэм шинжилгээний хурлыг 2024.05.24-ний өдөр зохион байгуулж, монгол хэл бичгийн эрдэмтэн багш, номын санчид зэрэг нийт 62 хүн оролцов. Тус хурлыг зохион байгуулах зардалд аймгийн ЗДТГ-аас 2,265,000 төгрөгийг шийдвэрлэсэн.<br>4. "Ю.Цэдэнбал Дарханы цогц бүтээн байгуулалт" номын нээлт, хэлэлцүүлэг аймгийн Төв номын санд 2024.06.01-ний өдөр болов. Тус номонд “Монголын төр нийгмийн зүтгэлтэн Ю.Цэдэнбал Дархан хотын хөгжилд оруулсан хувь нэмэр, тус хотод хийсэн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | айлчлалууд” сэдэвт түүхэн нийтлэлийг бичиж хэвлүүлсэн.<br>5. СББӨ-ийг өвлөн уламжлагч, Хэл шинжлэлийн ухааны магистр Ж.Эрхэмсайхан “Монголын төр нийгмийн зүтгэлтнүүдийн гар бичмэлд хийсэн судалгаа”, “Мянган жилийн буурал түүхтэй Монгол бичиг соёлоо дээдэлье” сэдэвт ахисан шатны сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж өөрийн хийсэн бүтээл туурвилын дээжээс сонирхуулла.<br>6. Төв номын сан, Хүүхдийн номын ордноос “Зохиолч уншигчдын уулзалт”-ыг ***7*** удаа зохион байгуулж 560 гаруй сурагч, иргэдийг хамруулсан.<br>7. “Мөнгөн мод-2024” улсын уралдаан тус аймгаас 3 хүнийг нэр дэвшүүлж материалыг ЗГХА-СУГ-т хүргүүлсэн.<br>8. Хонгор сумын Соёлын төв нь Хүүхдийн номын ордонтой хамтран орон нутгийн судлаач зохиолчдыг оролцуулан “Зохиолч уншигчдын уулзалт” зохион байгууллаа.<br><br>**Хүрсэн түвшин:**<br>Орон нутгийн судлаач, зохиолчдыг дэмжих чиглэлээр эрдэм шинжилгээний **2** хурал зохион байгуулж орон нутаг болон нийслэлээс 14 судлаач эрдэмтэд оролцсон.<br>Нийслэлд зохион байгуулагдсан ЭШХ-д 1 судлаач илтгэл хэлэлцүүлж оролцсон.<br>“Зохиолч уншигчдын уулзалт”-ыг ***6*** удаа, суманд 1удаа зохион байгуулсан. | |
| 2.6 | **Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5.1.17, Номын сангийн тухай хуулийн 23.2, 24.4, БСШУСайдын** | Орон нутгийн төсөв 7,641,600 төгрөг | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | Хэрэгжүүлсэн арга хэмжээ-20 | 20-оос доошгүй арга хэмжээ зохион байгуулсан байна. | "Үндэсний бичиг соёл, номын өдрүүд 2024" хаврын номын баярыг “Илүү их уншъя” уриан дор 5 дугаар сарын 18-наас 5 дугаар сарын 30-ны хугацаанд нийт 13 өдөр номоор дамжуулан иргэдийг соён гэгээрүүлэх олон талт үйл ажиллагааг зохион байгуулж өнгөрүүлэв. Үүнд:<br>➢ Төв номын сан 26 арга хэмжээг 59 удаа зохион байгуулж 11,347 хүн<br>➢ Хүүхдийн номын ордон 11 арга хэмжээнд 1826 хүн, | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | **2018 оны А/683 дугаар тушаал, МУ-ын Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлиг** "Номын баярын өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлэхэд дэмжлэг үзүүлэх, номоор дамжуулан иргэдийг соён гэгээрүүлэх олон талт ажлыг зохион байгуулах. | | | | | ➢ Шарын гол сумын Соёлын төв 8 арга хэмжээнд 524 хүн,<br>➢ Орхон сумын соёлын төв 3 арга хэмжээнд 110 хүн,<br>➢ Хонгор сумын Соёлын сум 5 арга хэмжээнд 158 хүнийг тус тус хамруулж нийт 53 арга хэмжээг 63 удаа зохион байгуулж 13,965 хүнийг хамрууллаа.<br>➢ "Хаврын номын баяр"-ын нээлтэд 28 байгууллагын 1565 иргэн оролцож 3000 гаруй иргэд хүрэлцэн ирж үзэж сонирхов.<br>➢ Тус аймгаас "Хаврын номын баяр"-ын хүрээнд зарласан "Номын сайн нөхөр" улсын уралдаанд ЕБС-ийн сургуулийн 6 анги, уншигчийн материалыг хүргүүлж ажилласан. Уралдаанд "Од" цогцолбор сургуулийн 5-10 ангийн хамт олон "Улсын Тэргүүний шилдэг уншигч хамт олон"-оор шалгарч Улаанбаатар хотноо "35 дахь Номын баяр"-ын нээлтийн үеэр УИХ-ын дарга Г.Занданшатараас шагналаа гардан авсан. Мөн аймгийн Засаг даргаас тус анги, хамт олныг "Олон улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр" шагнаж урамшууллаа.<br>➢ Хаврын номын баярыг зохион байгуулах зардалд аймгийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 02-А/98 захирамжаар 3.547.500 төгрөг, Төв номын сангаас 3,647,100 төгрөг нийт 7,641,600 төгрөг зарцуулсан.<br><br>**Хүрсэн түвшин:** "Номын баярын өдөр"- Хаврын арга хэмжээнд Соёлын 5 байгууллага нь нийт **53 арга хэмжээг** 86 удаа зохион байгуулж 13,965 хүнийг хамруулсан. "Номын сайн нөхөр" улсын уралдаанд "Од" цогцолбор сургуулийн 5-10 ангийн хамт олон "Улсын тэргүүний шилдэг уншигч хамт олон"-оор шалгарсан. Орон нутгийн төсөв, Байгууллагын үйл ажиллагааны зардлаас нийт 7,641,600 төгрөг зарцуулсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.7 | **Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйл.** Соёл, урлагийн байгууллагын орчин ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлагын стандартыг хангахад дэмжлэг үзүүлэх. | Орон нутгийн төсөв | Дэмжлэг үзүүлсэн арга хэмжээний тоо | - | 2-оос доошгүй арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх | 1. Залуучууд театр нь өөрийн болон гадны тоглолт, үзвэр үйлчилгээний тасалбарыг цахимаар https://ticket.mn/–ээр захиалан үзэх боломжийг бүрдүүлсэн.<br>2. Залуучууд театрын зүүн талын шатны 510 м$^2$ чулуун хавтан, 1600м$^2$ талбайд явган хүний 05м$^2$ бетонон хавтанг солих засвар шинэчлэлийн ажлыг орон нутгийн төсвийн 390,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Уран шанд” ХХК гүйцэтгэж байна. Гүйцэтгэл 70 хувьтай.<br>3. ОНХС-ийн 60.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Төв номын санд шаардлагатай харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан брайл үсгээр хэвлэх тоног төхөөрөмж нийлүүлэх худалдан авалт зарлагдсан ба цахимаар материал хүлээн авах ажил явагдаж байна.<br>4. Шарын гол сумын Соёлын төв нь сумын Музейтэй болох зорилгоор орон нутгийн төсвийн 76.0 сая төгрөгийн төсвөөр засварын ажлын зураг төсвийг шинээр хийх ажлын худалдан авалтыг дахин зарласан.<br>5. Хонгор сумын Соёлын төв ОНХС-ийн 10.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 560 ширхэг ном худалдан авч номын фондоо баяжуулсан.<br><br>**Хүрсэн түвшин:**<br>Соёл, урлагийн 4 байгууллагын орчин, үйлчилгээнд тавих ерөнхий шаардлагыг хангах хүрээнд нийт 536.0 сая төгрөгийн дэмжлэгийг аймаг, сумдын ЗДТГ-аас үзүүлсэн. | 100% |
| 2.8 | **Соёлын тухай хуулийн 4.1.2, 14.2.1, Монгол хэлний тухай хуулийн 7.2, 14.1.1, 17 дугаар зүйл, "Монгол бичгийн үндэсний** | Батлагдсан төсвийн хүрээнд | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | Үндэсний бичиг үсгийн баяр-2023, Эх хэлний өдөр-2023, "Хос бичигтэн байгууллага" арга хэмжээг хэрэгжүүлсэн. | 10-аас доошгүй арга хэмжээ зохион байгуулсан байна. | 1. “Үндэсний бичиг соёлын жил-2024”-ийн хүрээнд 13 заалт бүхий төлөвлөгөө боловсруулж хэрэгжилтийг ханган ажилласан. Үүнд:<br>➢ Соёл, урлагийн газар болон соёлын 7 байгууллага албаны үйл ажиллагаандаа Монгол бичгийн цахим сурах бичиг, толь бичиг, хөрвүүлэх программыг нэвтрүүлсэн. Тайлант хугацаанд дээрх байгууллагууд нийт 62 албан бичгийг хос бичгээр үйлдсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **хөтөлбөр III" 3.2.15.** “Үндэсний бичиг, соёлын жил-2024, "Эх хэлний өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлж, "Хос бичигтэн аймаг" уриалгыг гаргаж, Үндэсний бичиг соёлыг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах. | | | | | ➢ Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн судалгаанд соёлын байгууллагын 116 албан хаагч, Монгол бичгийн танхимын шалгалтад 1 албан хаагч тус тус хамрагдсан.<br>➢ Соёлын байгууллагууд "Хүмүн бичиг" сонинг улирал бүр захиалж өглөөний уншлага хийж хэвшсэн.<br>➢ Соёлын байгууллагын 8 албан хаагч удирдлагын академийн Монгол бичгийн дунд шатны сургалтад цахимаар хамрагдлаа.1. “Хос бичигтэн” арга хэмжээний хүрээнд үндэсний бичиг үсгээ сурч эзэмшин түгээн дэлгэрүүлэх олон талт сургалт, үзэсгэлэн, нөлөөллийн 12 ажилд 1092 иргэдийг хамруулсан.<br>➢ Монголын төр нийгмийн зүтгэлтнүүдийн гар бичмэлд хийсэн судалгаа”, “Мянган жилийн буурал түүхтэй Монгол бичиг соёлоо дээдэлье” сэдэвт Монгол бичгийн анхан болон ахисан шатны 8 удаагийн сургалтад 142 хүнийг хамруулсан.<br><br>2. “Хос бичигтэн” арга хэмжээний хүрээнд үндэсний бичиг үсгээ сурч эзэмшин түгээн дэлгэрүүлэх олон талт сургалт, үзэсгэлэн, нөлөөллийн 16 арга хэмжээнд 11503 иргэд олон нийтийг хамруулан зохион байгуулж, дэмжиж ажилласан. Үүнд:<br>➢ Харьяа номын сангуудтай хамтран үндэсний бичиг, үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх хүрээнд "Бийрэн бичлэг", "Уран уншлага"-ын уралдааныг 8 удаа зохион байгуулж 79 иргэнийг хамруулсан.<br>➢ "Хос бичигтэн-2025" эрдэм шинжилгээний хуралд ЕБС-ийн 32 багшийг хамруулсан.<br>➢ Үндэсний бичгийн "Түргэн уншлага", "Хэл бичгээ өвлөн бахархъя" эсээ бичлэг, "Эх хэлээ эрхэмлье" сайхан бичгийн уралдаанд нийт 460 иргэнийг хамруулсан.<br>➢ “Үндэсний бичгийн хурдан уншигч” уралдаанд 12 албан хаагч хамрагдсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ➢ СББӨ-ийг өвлөн уламжлагч Ж.Эрхэмсайханы монгол бичгээр буулгасан “Эвхмэл судар”, олон ястны дуунуудыг буулгасан “Хуйлмал ном”-ын видео бичлэгийг цахимд байршуулж 1830 хүнд сурталчлав.<br>➢ Сурагчдын бийрэн бичлэгийн бүтээл болон 54 боть номоор үзэсгэлэн дэлгэж 62 сурагчийг хамруулав.<br>➢ Иргэдийн эх хэлний мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор цахимд 3 удаа нийтлэл оруулж 385 хүнд хүргэсэн.<br>➢ Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр СББӨ-ийг өвлөн уламжлагч Х.Энхсарангийн Уран бичлэгийн үзэсгэлэн дэглэж 5000 гаруй иргэнд, “Гэр” үзэсгэлэнд тус аймгийн 3 иргэний уран бичлэг, хэвлэмэл номоор үзэсгэлэн дэглэж 12928 үзэгчдэд сурталчилан түгээн дэлгэрүүлсэн.<br><br>**Хүрсэн түвшин:** Үндэсний бичиг соёлыг сурталчлан таниулах ажлын хүрээнд нийт 21 арга хэмжээг зохион байгуулж 11770 гаруй иргэнийг хамруулсан. | |
| 2.9 | **Соёлын тухай хуулийн 11.4, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 16.1, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний** | Батлагдсан төсвийн хүрээнд | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | Хэрэгжүүлсэн арга хэмжээ-2 | 2-оос доошгүй арга хэмжээ зохион байгуулсан байна. | 1. “Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” сургалтад 22, "Үе тэнгийн дээрэлхэлт, гадуурхалт", "Цахим гэмт хэргийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь" лекцэд 20, “Цахим гэмт хэргээс хүүхдээ хэрхэн хамгаалах, урьдчилан сэргийлэх” сургалтад 25 , “Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд эрх тэгш оролцох” сургалтад 24, “Жендэрийн эрх тэгш байдал” сургалтад 28, Хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх “Харилцаа ба ёс суртахуун” сургалтад 90 нийт 6 сургалтад 209 соёлын ажилтныг хамруулсан.<br>2. Соёлын байгууллагуудын цахим хуудас болон мэдээллийн ил тод байдлын самбарт хүн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **төлөвлөгөөний 2.6.2.2** Хүчирхийлэл, хорт зуршил, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн соён гэгээрлийг дэмжих сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах. | | | | | худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх агуулга бүхий зурагт хуудас 5, электрон тамхины хор уршгаас сэргийлэх талаар 4, цахим халдлагаас сэргийлэх зөвлөмж 5, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх зөвлөмж 4, хүүхдийг ахуйн ослоос урьдчилан сэргийлэх зөвлөмж 8, “Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян”-д нэгдэж цахимаар 9, “Дээрэлхэл дэлгэрэх ёсгүй аян” сэдэвт 12 зурагт хуудас уриалга зэрэг нийт 47 урьдчилан сэргийлэх агуулга бүхий зөвлөмж, уриалга, зурагт хуудас, 23 шторк сурталчилгааг байршуулж олон нийтэд сурталчилж 8603 хүнд хүргэсэн.<br>3. Соёлын байгууллагуудын “Эцэг эхийн зөвлөл”-өөс 108 хүүхдийн тусламжийн утсыг таниулах, Хүүхдийн эсрэг хүчирхийллийг таних, бүх хэлбэрийн хүчирхийлэл дарамт, эрсдэлийг илрүүлэх чадавхийг нэмэгдүүлэх зорилгоор нийтдээ 12 удаагийн нөлөөллийн ажлыг зохион байгуулсан.<br><br>**Хүрсэн түвшин:**<br>Соёлын байгууллагуудын “Эцэг эхийн зөвлөл”-өөс 12 удаагийн нөлөөллийн ажлыг зохион байгуулсан.<br>Хүчирхийлэл, хорт зуршил, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн соён гэгээрүүлэх чиглэлээр нийт 6 сургалтад 209 соёлын ажилтныг хамруулж, цахим хуудас болон мэдээллийн самбарт урьдчилан сэргийлэх агуулга бүхий 47 зөвлөмж, уриалга, зурагт хуудас, 23 шторк сурталчилгааг байршуулж олон нийтэд сурталчилж 8603 хүнд хүргэсэн. | |
| **Гурав. Урлаг, уран бүтээлийг хөгжүүлэх чиглэлээр** | | | | | | | |
| 3.1 | **Соёлын тухай хуулийн 24.1** “GO MONGOLIA” аяны хүрээнд Соёлын аялал | Улс, орон нутгийн төсөв 67,0 сая | Зохион байгуулсан арга хэмжээ болон | - | 1-ээс доошгүй арга хэмжээг зохион байгуулж, дэмжсэн байна | Монгол Улсын Ерөнхий Сайдын “2024 оны эхний хагас жилд хэрэгжилтийг эрчимжүүлэх төсөл, арга хэмжээний тухай” 01 дүгээр албан даалгаврын хүрээнд “Бурхантын өвлийн наадам” эвэнт, “Дархан тайж хасарын нэрэмжит төвийн бүсийн аварга | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр орон нутгийн брэнд соёл, урлагийн наадмын арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх. | | оролцогчдын тоо | | | шалгаруулах монгол нохойн үзэсгэлэн, тэмцээн", Чингис мастер кросс" эвэнт, "Монгол гэр" үзэсгэлэн зэрэг нийт томоохон **4** арга хэмжээг зохион байгуулсан. **Үүнд**:<br>1. Соёлын аялал, жуулчлалыг хөгжүүлэх хүрээнд аймгийн ЗДТГ, Соёл, амралтын хүрээлэн, Залуучууд театр, Байгаль орчин аялал жуулчлалын газартай хамтран **"Бурхантын өвлийн наадам"-ыг** 4 төрлөөр зохион байгуулсан. Тус наадмыг зохион байгуулах зардалд аймгийн ЗДТГ-ын даргын 2024 оны 02-А/05 дугаар тушаалаар 15.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br>2. **"Дархан тайж хасарын нэрэмжит Төвийн бүсийн аварга шалгаруулах монгол нохойн үзэсгэлэн, тэмцээн**"-ийг 2024.04.06-ны өдөр зохион байгууллаа. Тус тэмцээнд ОХУ-ын Буриад улс, Улаанбаатар, Хөвсгөл, Төв, Орхон, Сэлэнгэ, Булган, Дарханаас 8 ангилалд 92 нохой оролцож 1500 гаруй үзэгч үзлээ. Тус тэмцээнийг зохион байгуулах зардалд аймгийн ЗДТГ-ын даргын 2024 оны 02-А/40 дүгээр тушаалаар 2.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br>**3.** Жил бүрийн гуравдугаар сард зохион байгуулдаг уламжлалт **"Чингис мастер кросс"** уралдааныг аймгийн Соёл, урлагийн газар, Авто мастеруудын холбоотой хамтран зохион байгуулав. Тус уралдаанд нийт 73 тамирчин өрсөлдсөн. Уралдааныг зохион байгуулах зардалд аймгийн ЗДТГ-ын даргын 2024 оны 02-А/47 дүгээр тушаалаар 8.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br>4. Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан **"МОНГОЛ ГЭР" үзэсгэлэн**д "Найрамдлын Дархан өргөө" гэрээр оролцож 12928 иргэдэд үйлчилсэн. Тус гэрийг урлахад Соёлын сайдын 2024 оны А/128 дугаар тушаалаар 30,0 сая, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын Иргэдийн оролцоотой төсөл хөтөлбөрөөс 10,0 сая төгрөг, аймгийн ЗДТГ-ын даргын 2024 оны 02-А/74 дүгээр тушаалаар 2,0 сая төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 5. Дархан, Шарын гол, Хонгор сумдад **“Наурыз-2024”** баярыг зохион байгуулж нийт 1043 иргэн тус тус оролцлоо.<br>6. Сумдын соёлын төвүүд нь Дархан хайрхан, Буурал хайрхан, Дунгар хайрханы тахилгын нээлт, урлагийн тоглолтыг хариуцан ажиллав. Шарын гол сумын Дархан хайрханы тахилгад 200 гаруй, Хонгор сумын “Буурал хайрханы тахилга”-ын тахилгад 200 гаруй, Орхон сумын Дунгар Хайрханы тахилгад 40 гаруй иргэн тус тус оролцлоо.<br>7. Найрамдал төслийн хүрээнд зохион байгуулагдсан нээлттэй форум хэлэлцүүлэгт оролцсон 9 орны 130 гаруй зочид төлөөлөгчдөд зориулж Залуучууд театрын уран бүтээлчид Ардын язгуур урлагийн тоглолтоор үйлчилсэн.<br><br>**Хүрсэн түвшин: “**GO MONGOLIA” аяны хүрээнд Соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр орон нутгийн онцлог бүхий нийт 4 томоохон арга хэмжээг, сумдад 6 арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж ажилласан. | |
| 3.2 | **Соёлын тухай хуулийн 24.1 Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.2.3**<br>Орон нутгийн угсаатан, ястны соёлын онцлогт суурилсан үндэсний болон сонгодог жүжиг, | Үйл ажиллагаа | Уран бүтээлийн тоо | Уран бүтээл - 7, Хүрсэн хүний тоо-13828 | 1-ээс доошгүй шинэ уран бүтээл туурвисан байна. | 1. Залуучууд театрын уран бүтээлчид нь сар шинийн баяраар “Ардын дууны түрлэг” цахим концертыг найруулан тавьж 3800 үзэгчдэд цахимаар хүргэсэн. Тус театр нь Үндэсний их баяр наадмын нээлтэд олон ястны онцлогийг агуулсан “Дөрвөн улирал”, Наадмын хүндэтгэлийн “Өнөд өвлөгдөх өв” концертыг тус тус толилуулахаар бэлтгэж байна. Мөн Язгуур урлагийг сурталчлах тайлбарт концертын бэлтгэлд орсон байна.<br>2. Шарын гол сумын Соёлын төв нь сар шинийн баяраар “Тал нутгийн залуус", "Наргиант бий", "Тойрон бужиг" бүжгийг тавьж 670 үзэгчдэд толилууллаа. Мөн “Наурыз”-ын баярын урлагийн тоглолтыг зохион байгуулж 1000 гаруй иргэдэд хүргэсэн.<br>3. Хонгор сумын Соёлын төв нь сар шинийн хүндэтгэлийн тоглолтыг 120 гаруй ахмадуудад толилууллаа. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | концерт, дуулалт жүжгийн бүтээлийг шинээр туурвихад дэмжлэг үзүүлэх. | | | | | 4. Орхон сумын Соёлын төв нь “Сэтгэлийн хэлхээ”, “Өв соёлоо дээдэлье” зэрэг 3 тоглолтыг 1604 үзэгчид хүргэлээ. “Өв соёлоо дээдэлье” тоглолтод СББӨ-ийг өвлөн уламжлагч 12, соёлын төвийн дэргэдэх дугуйлангийн 9 суралцагч нийт 21 хүнийг оролцуулсан.<br><br>**Хүрсэн түвшин:** Залуучууд театр орон нутгийн угсаатан, ястны соёлын онцлогт суурилсан шинэ концерт 2, сэргээгдсэн бүтээл 1, сумдын соёлын төвүүд нийт 6 концерт, урлагийн тоглолтыг найруулан тоглож нийт 3000 гаруй үзэгчдэд хүргэсэн. | |
| 3.3 | **Соёлын тухай хуулийн 24.1** Мэргэжлийн урлагийн байгууллагын урын сан дахь уран бүтээлийг цахим хэлбэрт шилжүүлэн, сан бүрдүүлж, цахим орчинд түгээх, орон нутгийн телевизээр дамжуулан иргэдэд хүргэхэд дэмжлэг үзүүлэх. | Үйл ажиллагаа | Үзэгчдийн тоо | Урын сан дахь ноот бичвэрийн 50 хувийг цахим хэлбэрт оруулах, уран бүтээлийг цахимжуулж хүн амын 25-аас доошгүй хувьд хүргэсэн байна. | Урын сан дахь ноот бичвэрийн 50 хувийг цахим хэлбэрт оруулах, уран бүтээлийг цахимжуулж хүн амын 25-аас доошгүй хувьд хүргэсэн байна. | 1. Залуучууд театрын уран бүтээлийн архивт хөгжмийн зохиолчдын туурвисан болон үндэсний хөгжимд зориулан хөрвүүлсэн 563 нэр төрлийн нот клавир хадгалагдаж байна. Уран бүтээлийн архивт хадгалагдаж буй хөгжмийн зохиолчдын нот, клавирыг цахим хэлбэрт оруулан сан хөмрөг үүсгэх ажил 65%-тай явагдаж байна. Нийт 3 боть буюу 356 нот, клавир буюу 3563 хуудас баримтыг цахим хэлбэрт шилжүүлэн ажилласан.<br>2. “Муурын байшин” хүүхдийн шинэ жүжгийн бичлэгийг архивлаж 2021 оны тус театрын бүтээл “Хамгийн сайхан хот кино концерт”-ыг 6 хэсэгт хуваан цахимд байршуулж 52300 үзэгчдэд хүргэлээ.<br>3. “Ардын дууны түрлэг” цахим концерт – үзэгч 3800, тус театрын дуучин, МУСТА Д.Бибишийн "Буурлын нутаг" - үзэгч 6100, МУСТА Б.Сорензонболдын Монгол ардын дуу "Эсгий тоорцог"- үзэгч 19000, МУСТА Б.Бат-Эрдэнэнийн "Би Монгол хүн" – үзэгч 5400, С.Сүхбатын "Шөнө амталсан нулимс" - үзэгч 12000, "Мандах нар” - үзэгч 944 зэрэг нийт 13 уран бүтээлийг цахимд байршуулж иргэд олон нийтэд сурталчилсан.<br><br>**Хүрсэн түвшин:**<br>Урын сан дахь ноот бичвэрийн 65 хувийг цахимжуулсан. 1 жүжиг, 2 цахим концерт, 5 уран | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бүтээлчийн дууг цахимд нийтэлж давхардсан тоогоор 99544 үзэгчдэд хүргэсэн. | |
| 3.4 | **Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 41.1. Засгийн газрын 2019 оны 369 дүгээр тогтоол** Үндэсний баяр наадмын соёл, урлагийн арга хэмжээний хүрээнд "Дээлтэй Монгол наадам", "Монголын сайхан орон" дүрслэх урлагийн үзэсгэлэн,"Монгол бахархал" гэрэл зургийн үзэсгэлэн зэрэг арга хэмжээг зохион байгуулах. | Орон нутгийн төсөв | Арга хэмжээний тоо | - | 3-аас доошгүй арга хэмжээ зохион байгуулсан байна | 1. Аймгийн Засаг даргын захирамжаар тус Газрын удирдлага Дархан-Уул аймгийн баяр наадмын урлаг, соёлын арга хэмжээг зохион байгуулах дэд ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар томилогдон ажиллаж байна. Урлаг, соёлын арга хэмжээний төлөвлөгөөнд "Дээлтэй Монгол" наадам", Монголын сайхан орон" дүрслэх урлагийн үзэсгэлэн, "Монгол бахархал" гэрэл зургийн үзэсгэлэн зэрэг 3 арга хэмжээг зохион байгуулахаар тусгаж, төсвийн төслийг боловсруулж хүргүүлэв.<br>2. Орхон сумын Соёлын төв “Дээлтэй монгол” өдөрлөгийг зохион байгуулж 40 сурагчийг хамрууллаа.<br>3. "Дархан зураглал" гэрэл зургийн үзэсгэлэнг "Солонго" гэрэл зургийн студи 25 жилийн ойгоо тохиолдуулан Залуучууд театр, ЕБ-ын 6 сургуульд гаргав.<br><br>**Хүрсэн түвшин:** Тайлант хугацаанд 2 арга хэмжээг зохион байгуулсан. Ирэх 7 дугаар сард зохион байгуулах 3 арга хэмжээний төлөвлөгөө, төсвийн төслийг боловсруулсан. | 100% |
| 3.5 | **Соёлын тухай хуулийн 24.1 Соёлын яамны стратеги төлөвлөгөөний 6 дүгээр** Олон улсын болон бүс нутгийн хэмжээнд зохион байгуулагдах уралдаан тэмцээнд | Орон нутгийн төсөв | Оролцогчдын тоо | Үндэсний болон олон улсын 20 уралдаан тэмцээнд уран бүтээлчид, хүүхэд залуучуудыг дэмжсэн. | 5-аас доошгүй уран бүтээлчид, хүүхэд багачуудыг дэмжсэн байна | 1. Гладнесс бүжгийн студийн 12 хүүхэд БНСУ-ын Сеүл хотноо зохион байгуулагдсан "World ballet grand prix” тэмцээнд оролцох зардалд дэмжлэг үзүүлж Залуучууд театрт тус бүжгийн студийн тоглолтыг 4 удаа зохион байгуулсан. Тоглолтод 88 хүүхэд оролцсон. БНСУ-д зохион байгуулагдсан тус тэмцээнээс 2 алт, 3 мөнгө, 2 хүрэл медалийн эзэд болсон. Тус студийн 15 хүүхэд Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан "World ballet grand prix Mongolia” тэмцээнд оролцож 2 мөнгө, 2 хүрэл 2, шүүгчийн нэрэмжит шагнал хүртсэн. Мөн “Номадик балет VIII уралдаан”-д оролцож 1 мөнгө, Тусгай | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэргэжлийн уран бүтээлчид, хүүхэд багачуудыг оролцуулахад дэмжлэг үзүүлэх. | | | | | байрын шагналыг хүртэв. Тус хамтлагийг нийт 8 арга хэмжээнд оролцоход дэмжлэг үзүүлсэн.<br>2. Шинэ алхам сургуулийн “Очис” хамтлагийн 16 хүүхэд БНСУ-д зохион байгуулагдсан KUACE ОУ-ын бүжгийн тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлж Залуучууд театрт 2 удаагийн тоглолтыг зохион байгуулсан. Тус тэмцээнээс 3 хүрэл медаль, тусгай байрын шагналыг хүртсэн.<br>3. Дархан хотын “Бундын тамга” хамтлагийн 6 гишүүнийг БНСУ-руу аялан тоглолтоор явахтай холбогдуулан БНСУ-ын элчин Сайдын яам руу 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 01/89 тоот албан бичгээр хүсэлт хүргүүлсэн.<br>4. 2024 оны 06 дугаар сарын 9-14-ний өдрүүдэд ЮНЕСКО-ийн Театр Урлагийн Институтийн Косово дахь салбар “МоноАкт”аас зохион байгуулах Олон улсын нэг хүний жүжгийн 16 дэх уралдаант фестивальд тус аймгийн Залуучууд театрын жүжигчин Ч.Дунгаамаа “Хайрт минь, энэ зөвхөн эхлэл нь” жүжгээр оролцох зардалд аймгийн ЗДТГ-ын даргын 2024 оны 02-А/114 дүгээр тушаалаар 1.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br>5. "Хаврын номын баяр"-ын хүрээнд зарласан “Номын сайн нөхөр” улсын уралдаанд ЕБС-ийн сургуулийн 6 анги, уншигчийн материалыг хүргүүлж "Од" цогцолбор сургуулийн 5-10 ангийн хамт олон /36 хүүхэд/ “Тэргүүний шилдэг уншигч хамт олон”-оор шалгарч 2024.05.28-ны өдөр Улаанбаатар хотноо "35 дахь Номын баяр"-ын нээлтийн үеэр УИХ-ын дарга Г.Занданшатараас шагналаа гардан авсан. Тэдгээр хүүхдүүдийг Улаанбаатар явах замын зардлыг Соёл, урлагийн газраас шийдвэрлэж өгсөн.<br>6. Номын баярын хүрээнд зохион байгуулсан “Ном” уран илтгэлийн уралдаанд 630,000 “Ангийн шилдэг номын сан уралдаанд 615,000, дүрийн тоглолттой уншигчийн бага хурал 457,500 нийт 1,702,630 төгрөгийн дэмжлэгийг аймгийн ЗДТГ-т уламжилж шийдвэрлүүлсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 7. Монголын хүүхдийн ордноос зохион байгуулсан “Би эстрадын дуучин 2024” улсын уралдаанд тус аймгаас 4 сурагч амжилттай оролцлоо.<br>8. Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан “Хүн домог” наадамд нийт 5 байгууллагын 150 гаруй бүжигчид оролцон 235 алтан медаль, 115 мөнгөн медаль, 39 хүрэл медаль хүртсэн амжилтыг үзүүллээ.<br>9. Япон улсад зохион байгуулагдах “Тайшо-Кото” уралдаанд оролцох “Шуранхай” хамтлагийн 5 гишүүний мэдээлэл болон дэмжлэг хүсэх тухай албан бичгийг аймгийн Засаг даргад уламжилсан.<br>10. Улаанбаатар хотноо 62 дахь жилдээ зохион байгуулагдсан “Хүүхдийн ертөнц-2024” гар зургийн улсын уралдаанд тус аймгийн 15 дугаар сургуулийн 4 дүгээр ангийн сурагч Б.Учралсайхан “Монгол” зургаар Тэргүүн байрт шалгарсан.<br><br>**Хүрсэн түвшин:** Олон улсын чанартай 4 уралдаан тэмцээнд 28 хүүхэд, 1 уран бүтээлч, гадаадад зохион байгуулах тоглолтод 6 уран бүтээлч, улсын чанартай уралдаан тэмцээнд 38 хүүхэд, 1 ангийн 36 хүүхэд, 5 байгууллагын 150 бүжигчдийг оролцоход дэмжлэг үзүүлж ажилласан. | |
| 3.6 | **Соёлын тухай хуулийн 24.1** Хүүхдэд зориулсан уран бүтээлийг нэмэгдүүлэхэд орон нутгийн уран бүтээлчдийн шинэ бүтээл, төсөл арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх, сурталчлах. | Улсын болон орон нутгийн төсөв | Уран бүтээлийн тоо | - | 2-оос доошгүй шинэ уран бүтээлд дэмжлэг үзүүлж, сурталчилж хамтран ажилласан байна | 1. Залуучууд театр нь Самуил Яковлевич Маршакийн зохиол, МУСТА Н.Баярцэнгэлийн найруулга “Муурын байшин” хүүхдийн драмын жүжгийг шинээр найруулан тавьж нийт 23 удаа тоглож 6800 хүүхдэд хүргэлээ. Тус уран бүтээлд 22,2 сая төгрөг зарцуулж 34,6 сая төгрөгийн орлого төвлөрүүлээд байна. Жүжгийн нүүр хувиргалтыг “Винк арт” студийн үүсгэн байгуулагч, зураач Б.Бат-Оюунаар ахлуулсан нүүр хувиргалтын баг хийж гүйцэтгэсний зэрэгцээ театрын уран бүтээлчдэд тайзны будалт, тусгай хувиргалт /special effect/, тусгай хувиргалтын материалтай хэрхэн харьцах техникийн сургалтыг 3 хоног зохион байгуулав. Сургалтын явц, тайзны бэлтгэлийг орон нутгийн RGB телевизээр сурталчилсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2. Намар цагийн үзвэрийн нээлтэд зориулсан “Дээрэмчин” драмын хүүхдийн жүжгийн уншлага эхэлсэн.<br>3. Залуучууд театрын дэргэдэх “Шонхоодой” цирк “Шилдэг үзүүлбэрүүд” тоглолтоо 500 үзэгчид, тус цирк болон Эрмүүн дугуйлангийн хамтарсан “Хүүхдийн ертөнцөөр” тоглолтыг 500 үзэгчид тус тус хүргэлээ.<br>4. “Инээмсэглэл бэлэглэх аян” хүүхдийн инээдмийн тоглолтыг тус театрын дугуй танхимд 2 удаа, их танхимд 1 удаа нийт 3 удаа тоглож 1000 гаруй хүүхдэд хүргэсэн.<br>5. “1 эзний 4 зарц”, “Ядмаа” хүүхдийн киног нийт 7 удаа гаргаж 1470 хүүхдэд үзүүлсэн.<br><br>**Хүрсэн түвшин:** Залуучууд театр нь “Муурын байшин” хүүхдийн жүжгийг шинээр толилуулсан. Тус уран бүтээлд 22,2 сая төгрөг зарцуулж 34,6 сая төгрөгийн орлого төвлөрүүлээд байна. Ирэх намар тоглогдох “”Дээрэмчин” хүүхдийн драм шинэ уран бүтээлийн уншлагыг эхлүүлсэн. Тус театрын дэргэдэх цирк, бүжгийн 2 дугуйлан уран бүтээлийн тайлан тоглолтоо тус тус тоглосон. Хүүхдэд зориулсан гадны 2 тоглолтод дэмжлэг үзүүлж ажилласан. Хүүхдийн баярын тоглолтод 4 дугуйлангийн 192 хүүхдийн уран бүтээлийг иргэдэд толилуулж дэмжин ажилласан. | |
| **Дөрөв. Соёлын өвийг хадгалж, хамгаалах чиглэлээр** | | | | | | | |
| 4.1 | **Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 37.4, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх** | Үйл ажиллагаа | Гэрээ байгуулсан дурсгалын хувь | Улсын хамгаалалтад орсон 1, Аймгийн хамгаалалтад орсон 2 дурсгалыг иргэн, хуулийн этгээдэд | 100 хувь гэрээ байгуулсан байна. | 1. Хонгор сумын нутагт орших 5 ширхэг Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг аймгийн Музейн бүртгэл мэдээллийн санд шинээр бүртгэв. Бүртгэлд 3 хөшөө дурсгал, 1 үйлдвэрлэлийн ул мөрийн дурсгал, хиргисүүрийг тус тус тусгай маягтын дагуу бүрдүүлж гэрэл зургаар баримтжууллаа.<br>2. Соёлын өвийн үндэсний төвөөс Дархан таван нуур ХХК-ийн ойролцоо Хүннүгийн үеийн булш байна гэсэн мэдээллийн дагуу Музей, Байгаль орчин аялал жуулчлалын газартай хамтран тус | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.3.6, Яамны стратеги төлөвлөгөөний 5 дугаар зорилт 5 дугаар арга хэмжээ:** Аймгийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалтыг иргэн, хуулийн этгээдэд гэрээгээр хариуцуулна. | | | гэрээгээр хариуцуулсан. | | газарт очиж 4 ширхэг 7*7 харьцах хэмжээтэй булшийг бүртгэн баримтжуулав.<br>3. Шарын гол сумын Хайрхан багийн нутаг дэвсгэрт орших "Буган чулуун хөшөө" дурсгалыг Хайрхан багийн иргэн Д.Мядагсүрэн, “Найрамдал өндөрлөг” хөшөөг “Цэгц туургатан” ХХК-д эзэмшүүлж гэрээгээр хамгаалах, хамтран ажиллах 3 талт гэрээг байгуулав.<br>4. Дархан сумын 14 дүгээр багийн нутаг дэвсгэрт орших Түүх, соёлын үл хөдлөх дурсгал болох “Найрамдал” өндөрлөг, “Лимбэчин хүү”, “Эх үрсийн элбэрэл”, “Буга” баримал хөшөөг Дархан хотын соёл, амралтын хүрээлэн ОНӨААТҮГ-т гэрээгээр эзэмшүүлж хамгаалах, хамтран ажиллах 3 талт гэрээг байгуулав. Цаашид хэрэгжүүлэх ажил болох “Лимбэчин хүү”, “Эх үрсийн элбэрэл” хөшөөний гадна өнгө төрхийг сэргээн засварлах ажил төсвийн талаар хэлэлцэв.<br><br>**Хүрсэн түвшин:** Тайлант хугацаанд түүх, соёлын үл хөдлөх дурсгал 6 газрыг шинээр бүртгэж, улсын тооллогоор бүртгэгдсэн түүх, соёлын үл хөдлөх 6 дурсгалыг 2 иргэн, 1 хуулийн этгээдэд гэрээгээр хариуцуулан хамгаалуулав. | |
| 4.2 | **Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 37.4, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.3.6, Яамны стратеги төлөвлөгөөний 5** | Үйл ажиллагаа | Шинээр нэмж бүртгэсэн баримтат өвийн тоо | 2023 онд 55 баримтат өвийг бүртгэсэн | 50-аас доошгүй баримтат өвийг шинээр нэмж бүртгэсэн байна. | 1. Музейн хүндэтгэлийн буланд дэглэгдсэн Дархан-Уул аймгийг хот болсонтой холбогдуулан Засаг захиргааны зохион байгуулалтад өөрчлөлт оруулах тухай зарлиг, Дархан хотод хороо захиргаа байгуулах тухай зарлиг, Шарын гол сумын хороог орон нутгийн хот болгох тухай зарлиг, Хороо байгуулах тухай зарлиг, Сэлэнгэ аймгийн Хонгор сумыг хороо болгож харьяаллыг өөрчлөх тухай зарлиг, Хороо байгуулах тухай зарлиг буюу зэрэг нийт 6 баримтат өвийг судалгаанд хамруулав.<br>2. Дархан сумын 11 дүгээр багийн иргэн Н.Амгаланд үе дамжин хадгалагдан ирсэн Догсо судар, Банзрагч судар, Алтангэрэл судар, Ил захидал, Бакула рембучи Хараагийн Дарь эх ламын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **дугаар зорилт 3 дугаар арга хэмжээ:**<br>Иргэд, сүм хийдэд хадгалагдаж байгаа баримтат өвийг бүртгэлд хамруулна. | | | | | Гэцогдаржайлан хийдэд ирсэн зураг зэрэг 5 баримтат өвийг бүртгэв.<br>3. Хараагийн Дарь эх ламын Гэцогдаржайлан хийдийн 12 баримтат өвийг бүртгэн баримтжуулав.<br>4. Дархан сумын 12 дугаар багийн иргэн Х.Мөнхцэцэгт хадгалагдаж буй 15 зурмал бурхан, 1 хос болор толь зэрэг 17 баримтат өвийг бүртгэн баримтжууллаа.<br>5. Шарын гол сумын Мэргэн даянчийн Гэлэгпэлжэйлин хийдэд хадгалагдаж буй 21 Дарь Эх, Очирваань, Гонгор, Ямандаг зэрэг 4 танка зургыг бүртгэн баримтжуулсан.<br>6. Хараагийн Дарь эх ламын Гэцогдаржайлан хийдийн лам Ёндонжамцад 5 үеэс хадгалагдаж байсан 5 баримтад өвийг бүртгэв.<br><br>**Хүрсэн түвшин:** Тайлант хугацаанд иргэд, сүм хийдэд хадгалагдаж байгаа нийт 32 баримтат өвийг бүртгэл мэдээллийн санд бүртгэж, тайланг салбарын хяналтын https://moc.igovernment.mn/ цахим санд сар бүр оруулж баталгаажуулж ажиллав. | |
| 4.3 | **Соёлын өвийг хамгаалах тухай 16.1.5, 26.1, Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоолоор баталсан "Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх журам"**<br>Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн | Үйл ажиллагаа | Тооллогын тайлан | 2018 онд явуулсан тооллогын тайлан | Хууль тогтоомжийн дагуу тооллогыг хийж, тайланг ирүүлсэн байна. | 1. Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллогыг улс орон даяар нэгдсэн журмаар III, IV улиралд зохион байгуулахтай холбогдуулан улсын тооллого хийх ажлын хэсгийг байгуулах тухай аймгийн Засаг даргын 2024 оны 01-А/19 дугаар Захирамжийг ЗГХА СУГ-т хүргүүлсэн.<br>2. Мөн Шарын гол, Орхон сумын Соёлын төвд СББӨ-ийг өвлөн уламжлагчдын тоо, чанарыг нэмэгдүүлэх, Музейн эд өлгийн зүйлийг бүртгэн баримтжуулах, Түүх, соёлын хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалтыг сайжруулах, холбогдох шинэ дүрэм журмыг таниулах зорилгоор “Түүх, Соёлын Үл Хөдлөх Дурсгалын тухай болон Дархан-Уул аймгийн дурсгалууд”, “Соёлын Биет Бус Өв, түүний төрөл тус аймгийн СББӨ-ийг өвлөн уламжлагчид”, "Соёлын үнэт зүйл худалдан авах журам", "Сан хөмрөгт үзмэр оруулах гаргах | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тооллогыг зохион байгуулах. | | | | | хөдөлгөөн"-ий дүрэм сэдвүүдээр сургалт хийж арга зүйн зөвлөгөө өгч ажиллав.<br>3. Хонгор сумын Соёлын төвийн даргын 2024 оны ”Эд хөрөнгийн тооллого явуулах тухай” тушаалын дагуу музейн ажилтныг оролцуулан хөдлөх дурсгалт зүйлийн тооллогыг зохион байгуулсан.<br>4. Орхон сумын Соёлын Төвийн Музейн сан хөмрөгт хадгалагдаж буй үзмэрийн бүртгэл, тооллогод хяналт тавьж арга зүйн зөвлөгөө өгөв.<br>5. Бүртгэл тооллогод Хонгор сум 115 дэсийн 120, Орхон сум 28 дэсийн 31 үзмэрийг хамруулав.<br><br>**Хүрсэн түвшин:** Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн Улсын тооллогыг зохион байгуулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулсан. Хонгор, Орхон сумдын соёлын төвийн Музейн сан хөмрөгт хадгалагдаж буй үзмэрийн бүртгэл, тооллогод хяналт тавьж арга зүйн зөвлөгөө өгөв. Бүртгэл тооллогод Хонгор сум 115 дэсийн 120, Орхон сум 28 дэсийн 31 үзмэрийг хамруулав. Тооллого зохион байгуулах урьдчилсан бэлтгэл бүрэн хангагдсан. | |
| 4.4 | **Соёлын тухай хуулийн 21.1.1, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 39.3** Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийг сурталчлан алдаршуулах арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх. | Үйл ажиллагаа | Дэмжлэг үзүүлсэн өвлөн уламжлагчийн тоо | Бүртгэлтэй 54 өвлөн уламжлагч | 10-аас доошгүй өвлөн уламжлагчийг сурталчлан алдаршуулахад дэмжлэг үзүүлсэн байна. | 1. Дархан-Уул аймгийн хэмжээнд 84 өвлөн уламжлагч www.ich.mongoluv.mn улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд бүртгэлтэй байдаг ба үүнээс МУ-аас ЮНЕСКО-ийн жагсаалтад орсон Морин хуур, Монгол Ардын уртын дуу, Монгол бий биелгээ, Монголын Уламжлалт Хөөмийн урлаг, Монгол уран бичлэг зэрэг өвийг өвлөсөн Дархан, Шарын гол, Хонгор, Орхон сумын харьяат 29 өвлөн уламжлагчид БАТЛАМЖ гардуулж ЮНЕСКО-ийн яаралтай болон төлөөллийн жагсаалтад бүртгэгдсэн өвийг өвлөн уламжилж, хойч үедээ түгээн дэлгэрүүлэх, өвлүүлэн үлдээх үүргээ биелүүлж буйд Талархал илэрхийлэв.<br>2. “Монгол улсын шилдэг өвлөн уламжлагч” номинаци, “Мөнгөн мод 2023” наадам, “Монгол туургатан хэл хуурын танхим байгуулах” зэрэг 3 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | арга хэмжээний зохион байгуулагчдад СББӨ-ийг өвлөн уламжлагч 4 хүний мэдээллийг хүргүүлсэн.<br>3. МҮОНТ-ийн “Монгол Түмний Мэнд” нэвтрүүлэгт СББӨ-ийг өвлөн уламжлагч гэр бүлийн 5 гишүүнийг, UBS телевизийн "21 Өв, соёл" нэвтрүүлэг, Цэц.мн цахим сайтын “Хотон” бий биелгээ, Монголын хамгийн өндөр ой тогтоолттой хүн, MOZU брэнд, Морьт харваа зэрэг цуврал нэвтрүүлэгт тус бүр 1, RGB телевизийн “Сайхан шинэлээрэй” нэвтрүүлэгт 3, Гэр бүтээх төслийн контентод 2 нийт 15 СББӨ-ийг өвлөн уламжлагчийг төв, орон нутгийн телевизийн нэвтрүүлэгт оролцуулж 16943 үзэгчдэд сурталчиллаа.<br>4. ЮНЕСКО, Соёлын яамны дэмжлэгтэйгээр СУИС-ийн Соёлын сургуулиас хэрэгжүүлж буй төслийн хүрээнд “Бий биелгээний шавь сургалтын танхим”-ын нээлтэд 12 СББӨ-ийг өвлөн уламжлагч, бийчдийг оролцуулж танхимаар 30, цахимаар 426 үзэгчдэд сурталчиллаа.<br>5. Музей "Gen-Z ба Монгол соёл", "Уламжлалт аргаар сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах", "Монгол ёс заншил", "Эрүүл аж төрөх ёс", “Монгол бий биелгээг өвлүүлэн уламжлуулж, оршин тогтнох чадварыг бэхжүүлэх нь”, “Өв соёл-Цагаан сар” зэрэг 4 сургалт, 3 хэлэлцүүлэг, 1 үзэсгэлэнд СББӨ-ийг өвлөн уламжлагч 7 хүнийг урилгаар оролцуулж танхимаар 330, цахимаар 9893 үзэгчдэд сурталчиллаа.<br>6. Орхон сумын Соёлын төв, сумынхаа 12 СББӨ-ийг өвлөн уламжлагчид, төвийн дэргэдэх дугуйлангийн 9 суралцагчидтай хамтран "Өв соёлоо дээдэлье" тоглолтыг 2024 оны 05 дугаар сард 2 удаа тоглож нийт 350 гаруй үзэгчдэд хүргэлээ.<br>7. "Уламжлалт өв соёлоо дээдлэе" уралдааныг Хорол тоглоом, Шагайн харваа, Морь уралдуулах, Монгол бичгээр эх унших, Оньсон тоглоом, Үндэсний бөх, Дэмбээ, Шагай шүүрэх зэрэг 10 төрлөөр 2024.02.06-ны өдөр зохион байгуулж 40 гаруй СББӨ-ийг өвлөн уламжлагчийг оролцууллаа. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 8. Сумдын Соёлын төвүүд буюу Шарын гол 6, Орхон сум 22, Хонгор сум 14 СББӨ-ийг өвлөн уламжлагчийг тус тус сум орон нутагтаа сурталчлан алдаршууллаа.<br>9. 2024 оны 05 дугаар сарын 03-12-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан “Гэр” үзэсгэлэнд тус аймгийн СББӨ-ийг өвлөн уламжлагчийн 35 гаруй бүтээлийг **12928** үзэгчид сурталчиллаа.<br>10. Монгол Угсаатан Хэл хуурчдын холбооноос зохион байгуулсан Хэл хуурчдын анхдугаар чуулганд тус аймгаас СББӨ-ийг өвлөн уламжлагч 3 иргэнийг оролцуулав. Улмаар тус аймгийн Хэл хуурчдын анхдугаар уулзалтыг 2024.05.30-ны өдөр зохион байгуулж Хэл хуур, Хулсан хуур, Төмөр хуур, Ясан хуур, Нуман хуур судлаач, сонирхогч, СББӨ-ийг өвлөн уламжлагч 15 иргэнийг оролцуулсан. Монгол угсаатан хэл хуурчдын холбооны гишүүнээр тус аймгийн 8 өвлөн уламжлагч бүртгэгдсэн.<br><br>**Хүрсэн түвшин:** 16 арга хэмжээний хүрээнд 33 СББӨ-ийг өвлөн уламжлагчийг оролцуулан танхимаар 360 иргэнд, цахимаар 27262 үзэгчдэд сурталчиллаа. | |
| 4.5 | **Соёлын тухай хуулийн 21.1.1, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 264 дүгээр тогтоол** “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестиваль зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ. | Орон нутгийн 28.0 сая | Фестивальд оролцсон эсэх Зарцуулсан төсөв | "Нүүдэлчин" дэлхийн соёлын фестивалийг 2023 онд зохион байгуулсан. | Фестивальд орон нутгийн оролцоог хангаж оролцсон байна.<br>Арга хэмжээнд дэмжлэг үзүүлж санхүүжүүлсэн байна. | 1. МУЗГ-ын гишүүн, Соёлын сайд болон Дархан-Уул аймгийн Засаг дарга нарын 2024 онд хамтран ажиллах гэрээнд тусгагдсаны дагуу “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестиваль 2024.08.17-20-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулагдахтай холбогдуулан оролцох ажлын хэсгийн бүрэлдэхүүн, холбогдох зардлын төсөв болох 28.0 сая төгрөгийг аймгийн ИТХ-ын хуралдаанаар шийдвэрлүүлсэн.<br>2. ЗГХА СУГ-ын цахим хурлаас өгсөн чиглэлийн дагуу Залуучууд театр, Музейн удирдлага, Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч нарт урьдчилсан мэдээллийг хүргэж бэлтгэл хангах үүрэг өгсөн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | **Хүрсэн түвшин:** Орон нутгаас санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийн хүрээнд төсвийн асуудлыг шийдвэрлүүлж, төсвийн төслийг боловсруулан удирдлагуудад танилцуулаад байна. | |
| **Тав. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр** | | | | | | | |
| 5.1 | **Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.2.4, Засгийн газрын 2022 оны 314 - р тогтоол, Засгийн газрын 2023 оны 481 дүгээр тогтоол.** Аймаг, бүс нутгийн онцлогт тулгуурласан соёлын бүтээлч үйлдвэрлэлийн зураглал, стратеги төлөвлөгөөг боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах. | 1200.0 | Баримт бичиг батлагдсан байна. | - | Батлагдсан төлөвлөгөө - 1 Хэрэгжилтийн тайланг Соёлын яаманд ирүүлсэн байна. | 1. Аймаг, бүс нутгийн онцлогт тулгуурласан соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дэмжих ажлын хүрээнд Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэл кино, дуу дүрсний урлагийг сонгон **“Кинонд ээлтэй хот”** зорилт дэвшүүлэн ажиллаж байна. Аймгийн Засаг дарга, Кино урлагийн зөвлөлийн хамтын ажиллагааны “Санамж бичиг”-ийн хүрээнд орон нутгаас кино зураг авалтын багуудад дэмжлэг үзүүлж ажиллаж байна.<br>➢ 2024 оны эхний хагас жилийн байдлаар гадаадын 1, дотоодын 3 киноны зураг авалтыг Дархан хотноо зохион байгуулахад хамтран ажилласан.<br>➢ “Кино павильон” байгуулахад орон нутгийн төсөвт 1.2 тэрбум төгрөгийг төсөвлүүлж зураг, төсвийн ажлыг аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ, Авто-Кад ХХК, аймгийн Кино урлагийг хөгжүүлэх ажлын хэсэгтэй хамтран гүйцэтгэж байна. Энэ хүрээнд холбогдох хууль тогтоомж, стандарт, барилгын зураг төслийн талаар мэдээлэл солилцож, олгогдсон газарт геодизийн ажил хийгдсэн.<br>➢ “Хамгийн сайхан нь 2” киноны нээлтийг хамтран зохион байгуулж тус киноны найруулагчийг “Найрамдлын Дархан” тэмдгээр шагнаж урамшуулсан.<br>➢ Уран бүтээлчдийн кино зохиол бичих ур чадварыг дээшлүүлэх олон улсын зах зээлд чиглэсэн чанартай сайн кино хийх бүх талын суурь мэдлэгийг олгох зорилготой “Холливудын кино зохиол бичих” сургалтад 1 уран бүтээлч хамрагдаж төгссөн. Сургалтыг АНУ-ын Лос Анжелес хотод 15 жил холливудын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | кино зохиол бичих арга зүйд суралцсан мэргэжлийн багш Ш.Энхбаяр удирдсан.<br><br>2. Шинээр боловсруулж буй "Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал"-д төвийн бүсэд хэрэгжүүлэх соёлын бүтээлч үйлдвэрлэлийн арга хэмжээ, томоохон төслүүдийн байршлын санал боловсруулж Соёлын яаманд хүргүүлсэн.<br><br>**Хүрсэн түвшин:** Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэл кино, дуу дүрсний урлагийг сонгон “Кинонд ээлтэй хот” зорилт дэвшүүлэн Санамж бичиг байгуулан ажиллаж байна. Орон нутагт Кино павильон барихад шаардагдах 1.2 тэрбум төгрөгийг орон нутгийн төсөвт тусгуулж геодезийн ажил хийгдсэн. Тайлант хугацаанд гадаадын 1, дотоодын 3 киноны зураг авалт, 1 киноны нээлтийг Дархан хотноо зохион байгуулахад хамтран ажилласан. | |
| 5.2 | **Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.2.4**<br>Хувийн хөрөнгө оруулалтаар соёлын үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй иргэн, хуулийн этгээдийн санал санаачилга, бүтээлч үйл ажиллагааг дэмжих, урамшуулах. | Орон нутгийн төсөв | Иргэн, хуулийн этгээдийн тоо | Нийт 15 иргэн, хуулийн этгээдэд дэмжлэг үзүүлсэн. | 5 -аас доошгүй иргэн хуулийн этгээдийг дэмжсэн байна. | 1. Соёлын үйл ажиллагаа эрхэлж буй оюутнуудын санал санаачилга, бүтээлч үйл ажиллагааг дэмжиж урамшуулах зорилгоор улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 44.5 сая төгрөгийн үнэ бүхий 23 нэр төрлийн 42 ширхэг хөгжмийн зэмсгийг хүлээн авч, аймгийн Оюутны холбооны дэргэдэх амьд хөгжмийн “Хуурцаг” хамтлагтай гэрээ байгуулан үнэ төлбөргүй ашиглуулж байна.<br>2. “Гэр” үзэсгэлэнгийн хүрээнд Дарханы Зураач, урчуудын эвлэлийн гишүүн, MOZU брэндийг үүсгэн байгуулагч 2 зураачтай монгол зургаар чимэглэсэн халх монгол гэрийг бүтээх, урлах 30,370,000 төгрөгийн ажлын гэрээ байгуулж хамтран ажилласан. Аймгийн Соёл, урлагийн газраас уран бүтээлчдэд Талархал гардууллаа.<br>3. Дарханы Зураач, урчуудын эвлэлийн 3 уран бүтээлчийн 5 уран зургийг дуудлага худалдаагаар, “Дөрвөн улирал” алчуурыг 2 арга хэмжээнд нийт 60 ширхэгийг тус тус худалдаалж соёлын үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй уран бүтээлчдийг дэмжиж ажилласан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 4. Солонгос улсын Жонжү хотод болох СББӨ-ийг сурталчлах олон улсын шагнал гардуулах ёслол JIAPICH-д 1 өвлөн уламжлагч, “Мөнгөн мод” наадамд 3, "Horeca mongolia conference 2024"-д 1, Цагаан сарын үзэсгэлэн худалдаанд 3 ААНБ-ыг дэмжин оролцууллаа.<br>5. “Дархан хүү”, “Тэнгэрийн бүжиг”, “Үе тэнгийхэн”, “Шилдэг үзүүлбэрүүд”, “Хүүхдийн ертөнцөөр”, “Гладнесс”, “Очис”, “Muugii’s dance клубуудын тоглолтыu зохион байгуулахад дэмжлэг үзүүлэв. Кинонд ээлтэй хот зорилтын хүрээнд гадаадын 1, дотоодын 3 киноны зураг авалт, 1 киноны нээлтийг хамтран зохион байгуулж дэмжлэг үзүүлсэн.<br>6. “Гладнесс” бүжгийн студийн багш С.Үүрийнцолмонг “Дархан сумын онцлох иргэн”, “Хас” хамтлагийн дуучин Н.Батболд, Зураач Ч.Нарангарав, С.Ариунбилэг, киноны найруулагч О.Батзориг нарт “Найрамдлын Дархан” тэмдэг, Солонго гэрэл зургийн студийн 2 уран бүтээлчийг аймгийн Засаг даргын Жуух бичиг, 2 уран бүтээлчийг “Найрамдлын Дархан” тэмдэгт нэр дэвшүүлж тус тус шагнаж урамшууллаа.<br><br>**Хүрсэн түвшин:** Хувийн хөрөнгө оруулалтаар соёлын үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй оюутнуудын хамтлагийн идэвх санаачилгыг дэмжиж 23 нэр төрлийн 42 ширхэг хөгжмийн зэмсгийг УТХО 44.5 сая төгрөг, 2 уран бүтээлчтэй 30,370,000 төгрөгийн гэрээ байгуулж ажилласан.<br>8 тоглолтыг зохион байгуулахад дэмжиж, 109 бүтээгдэхүүнийг худалдаалж, 5 уран бүтээлч, 3 ААНБ-д дэмжлэг үзүүлсэн. Гадаадын 1, дотоодын 3 киноны зураг авалт, 1 киноны нээлтийг хамтран зохион байгуулсан. 9 уран бүтээлчийг шагнаж урамшуулж, 2 уран бүтээлчид Талархал гардуулсан. | |
| 5.3 | **Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны** | Орон нутгийн төсөв | Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | Тандан судалгаа хийгдсэн. | Дүгнэлт- 1<br>2-оос доошгүй арга хэмжээг | 1. Дархан-Уул аймгийн соёл, урлагийн байгууллагуудын газар эзэмшил, ашиглалтын байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | **үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.2.4** Соёл урлагийн байгууллага, концертын танхим, караоке, бар, ресторанд оюуны өмч, зохиогчийн эрхийн талаарх тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж шаардлагатай арга хэмжээг авах. | | | | хэрэгжүүлсэн байна. | 2024.05.16-30-ны өдрүүдэд хийж дүнгийн танилцуулгыг 2024.06.05-ны өдрийн 01/180 тоот албан бичгээр Соёлын яамны Салбарын хяналтын газрын дарга Д.Ренчиндоржид хүргүүлсэн.<br>2. Соёлын яамнаас "Оюуны өмч, зохиогчийн эрх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь" сэдэвт цахим сургалтыг орон нутгийн соёлын байгууллагуудын удирдлага, албан хаагчдын дунд зохион байгуулсан. Сургалтад харьяа соёлын 5 байгууллагын 38 албан хаагч хамрагдсан байна.<br>3. Монгол Улсын Зохиогчийн эрхийн тухай хуульд заасны дагуу Дархан хотын бэлгэдэл баатар “Нада буга”-ын дүрийг аймгийн Прокурорын газарт 3 төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, анхааруулах, сануулах цуврал контентод ашиглах зөвшөөрөл өгч хамтран ажиллаж байна. Мөн Европын холбооны санхүүжилттэй Найрамдал төсөл нь тус дүрээр зөөлөн тоглоом үйлдвэрлэж байна.<br>4. Соёлын сайдын 2024 оны А/106 дугаар тушаалаар “Төсвийн хөрөнгөөр бүтээсэн бүтээл, соёлын биет бус зүйлийн оюуны өмч, зохиогчийн эрхийг бүртгэн баримтжуулах, ашиглалтын талаар дүгнэлт, зөвлөмж гаргах, соёл, урлагийн байгууллагад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх” чиг үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тус газрын дарга томилогдсон. Ажлын хэсгийн аймагт ажиллах удирдамжийг орон нутгийн соёлын байгууллагуудад танилцуулж бэлтгэл хангуулж байна.<br><br>**Хүрсэн түвшин:** Соёл, урлагийн байгууллагуудын газар эзэмшил, ашиглалтын байдалд урьдчилан сэргийлэх хяналтыг 1 удаа хийсэн. Төсвийн хөрөнгөөр бүтээсэн бүтээл, соёлын биет бус зүйлийн оюуны өмч, зохиогчийн эрхийг бүртгэн баримтжуулах, ашиглалтын талаар соёл, урлагийн байгууллагын албан хаагчид 2 удаа сургалтад хамрагдсан. Зохиогчийн эрхийн тухай хуульд | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | заасны дагуу “Нада буга”-ын дүрийг төрийн болон олон улсын байгууллагуудын үйл ажиллагаанд ашиглах зөвшөөрөл өгч хамтран ажиллаж байна. Соёл, урлагийн байгууллагад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тус газрын дарга томилогдон ажиллаж байна. | |
| 5.4 | **Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.2.4** Соёл урлагийн байгууллагуудын мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтэц (өндөр хурдны интернэт) -ийн өнөөгийн нөхцөл байдлыг үнэлж дүгнэлт гаргах, хүртээмжийг нэмэгдүүлэх. | Байгууллагын үйл ажиллагаа | Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | - | Дүгнэлт- 1 3-аас доошгүй арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Өндөр хурдны интернетэд холбогдсон соёл, урлагийн байгууллагын тоо 100 хувь | 1. Тус газраас харьяа соёлын байгууллагуудын мэдээлэл, харилцаа холбооны өнөөгийн нөхцөл байдалд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ийн Харилцаа, холбооны хяналтын улсын байцаагчтай хамтран холбогдох албан тушаалтнуудыг байлцуулан хийж гүйцэтгэсэн. Шалгалтаар соёлын байгууллагууд мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтэц шилэн кабельд бүрэн холбогдож, цахим үйлчилгээг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагууд хаанаас ч, хэзээ ч өөрт байгаа боломжит төхөөрөмжөөрөө авах нөхцөлийг бүрдүүлсэн байна. Цаашид цахим үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах хүрээнд 6 арга хэмжээг авч ажиллахыг бичгээр зөвлөсөн. Үүнд:<br>➢ Байгууллагын 2024 оны батлагдсан төсөвт багтаан интернэт үйлчилгээний хурдыг нэмэгдүүлэхэд анхаарч, гэрээгээ шинэчлэн байгуулах;<br>➢ Wireless router-ийн тоог нэмэгдүүлж, сүлжээний зохион байгуулалтыг сайжруулах;<br>➢ Байгууллагын дотоод сүлжээг стандартын шаардлага хангасан материал, тоног төхөөрөмж ашиглан сүлжээний кабель, бусад хэрэгслийг ажиллагсдын ажиллах орчинд тохирсон байдлаар эмх цэгцтэй зохион байгуулах, галын аюулгүй байдлыг хангах;<br>➢ Мэдээллийн системийн сүлжээний мэдээллийн сангийн аюулгүй байдал алдагдах, мэдээлэл болон мэдээллийн системд зөвшөөрөлгүй хандах, мэдээллийг ашиглах, ил болгох, өөрчлөх, хуулах, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | устгах, мэдээллийн системийн үйл ажиллагааг тасалдуулах, халдлагад өртөх эрсдэлээс хамгаалах;<br>➢ Үйлчлүүлэгчдэд мэдээлэл, харилцаа холбооны хэрэгцээг дээд зэргээр хангах, ажилтнууд хоорондоо мэдээллээ харилцан солилцох боломжит техник хэрэгслээр хангах нөхцөлийг бүрдүүлэх;<br>➢ Соёлын үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх боломжийг нэмэгдүүлж, шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлэх боломжийг эрэлхийлэх, төсөл, хөтөлбөрт хамрагдах тал дээр анхаарч ажиллах шаардлагатай байна.<br><br>**Хүрсэн түвшин:** Соёл урлагийн байгууллагуудын мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтэц (өндөр хурдны интернэт) - ийн өнөөгийн нөхцөл байдлыг үнэлэх төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хамтарсан байдлаар хийж гүйцэтгэсэн.<br>**С**оёлын байгууллагууд мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтэц шилэн кабельд бүрэн холбогдож хаанаас ч татаж авах боломж бүрдсэн байна. | |

Соёлын сайд, Дархан-Уул аймгийн Засаг дарга нарын хооронд байгуулсан гэрээний хоёрдугаар хавсралт

**ТӨРИЙН ЧИГ ҮҮРГИЙГ ТӨЛӨӨЛӨН ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ДАГУУ ХЭРЭГЖҮҮЛЭХ СОЁЛЫН САЛБАРЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ**

(сая төгрөгөөр)

| № | Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил | Төсөвт өртөг /сая.төг/ | Санхүүжүүлсэн дүн /сая.төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин /хэрэгжилт болон тайлбар/ | Гүйцэтгэл -ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **СОЁЛЫН САЙД** | | **15,900.50** | **10,847.44** | | | | | |
| 1 | Орон нутагт эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтэд тавих техник хяналтыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэн, тайлагнаж, зардлыг санхүүжүүлнэ. | 16,400.50 | 11,347.34 | Барилгын ажлын үе шатанд хяналт тавьсан байдал | | Барилга угсралтын ажлын явцад чанарын хяналтыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэн, үр дүнгээр нь санхүүжилтийг олгосон байх. | 1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар соёлын салбарын тоног төхөөрөмжийг шинэчлэх төслийн хүрээнд Сангийн яамнаас эрх шилжүүлсэн 500.0 сая төгрөгийн тендер зарлагдан худалдан авалт хийгдэж, 7 нэр төрлийн 15 ширхэг техник, тоног төхөөрөмжүүдийг соёл, урлагийн 8 байгууллагад хүлээлгэн өгсөн. Үүнээс:<br>-Залуучууд театрт 450.0 сая төгрөгийн үнэ бүхий 6x12 метрийн хэмжээтэй гадна зориулалтын лед дэлгэц, 16x10 метрийн хэмжээтэй зөөврийн тайз;<br>-Соёл, урлагийн 7 байгууллагад 5 нэр төрлийн 13 ширхэг 49.9 сая төгрөгийн үнэ бүхий техник тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн.<br>2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй 14.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | “Музей, номын сангийн цогцолбор”-ын барилга угсралтын ажил 89%-ийн гүйцэтгэлтэй байна.<br>**Хүрсэн түвшин:**<br>-Тендерт шалгарсан Прожект Девелопмент ХХК, Сүвэн-Уул ХХК-иас инженер, техникийн мэргэжлийн баг ирж заавар зөвлөгөө өгч, сургалт зохион байгуулсан. Үр дүнгээр нь санхүүжилтийг бүрэн олгосон болно.<br>-Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ээс гүйцэтгэлээр санхүүжилтийг үзүүлж, байнгын хяналтыг Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газраас тавьж, 7 хоног бүрийн Мягмар гарагт илтгэх хуудсаар холбогдох газруудыг мэдээллээр ханган ажиллаж байна. | |
| 2 | Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар соёл, урлагийн байгууллагын барилгад засвар хийж, хүчин чадлыг нэмэгдүүлнэ | 436.9 | 590.9 | Засвар тохижилт хийсэн объектын тоо | - | 5-аас доошгүй барилгад засвар, тохижилт хийх, хүчин чадлыг нэмэгдүүлнэ. | 1. Орон нутгийн замын сангийн хөрөнгө оруулалтаар Залуучууд театрын гадна зогсоолын 185.9 сая төгрөгийн өртөгтэй засварын ажлын гүйцэтгэгчээр Билигт-Инжиниринг ХХК шалгарч, зам засварын ажил төлөвлөсөн хугацааны дагуу 40%-ийн гүйцэтгэлтэй явж байна.<br>2. Залуучууд театрын зүүн талын шатны 510 $м^2$ чулуун хавтан, 1600$м^2$ талбайд явган хүний 05$м^2$ бетонон хавтанг солих засвар шинэчлэлийн ажлыг орон нутгийн төсвийн 390,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Уран | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | шанд" ХХК гүйцэтгэж байна. Гүйцэтгэл 70 хувьтай.<br>3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Орхон сумын Соёлын төвийн гадна пасад засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах 100.0 сая төгрөгийн худалдан авах ажиллагаа зарлагдан материал хүлээн авах ажил үргэлжилж байна.<br>4. Шарын гол сумын Соёлын төв нь ОНХС-ийн 15,0 сая төгрөгөөр гэрэлтүүлгийн тоног төхөөрөмж суурилуулсан. Мөн сумын Музейтэй болох зорилгоор орон нутгийн төсвийн 76.0 сая төгрөгийн төсвөөр засварын ажлын зураг төсвийг шинээр хийх ажлын худалдан авалтыг дахин зарласан.<br><br>**Хүрсэн түвшин:**<br>Орон нутгийн замын сангаар 1 объектод, орон нутгийн хөгжлийн сангаар 2 объектод засвар үйлчилгээ хийгдэхээс 2 ажил нь эхэлсэн, 2 ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын тендер зарлагдсан байна. | |
| **I. Барилга байгууламж** | | **5,600.50** | **10,547.44** | | | | | |
| 3 | Музей, номын сангийн цогцолбор /Дархан-Уул, Дархан сум/ | 15,600.50 | 10,547.44 | Гүйцэтгэлээр санхүүжүүлэх дүн | 30% | Барилга угсралтын ажлыг 70%-д хүргэнэ. | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй 14.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй "Музей, номын сангийн цогцолбор"-ын барилга угсралтын ажил 2021.07.01-ний | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | өдрөөс эхэлсэн ба гүйцэтгэгчээр нь Воком Констракшн ХХК шалгаран ажиллаж байна.<br>Өнөөдрийн байдлаар барилга угсралтын ажил 89%-ийн гүйцэтгэлтэй байна.<br><br>**Хүрсэн түвшин:** Гүйцэтгэлээр 4.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг үзүүлсэн байна. | |
| **II.Тоног төхөөрөмж** | | **300.00** | **300.00** | | | | | |
| 4 | Соёлын салбарын тоног төхөөрөмж /Дархан-Уул/ | 300.00 | 300.00 | Гүйцэтгэлээр санхүүжүүлэх дүн | 0% | Соёлын салбарт тоног төхөөрөмж нийлүүлсэн байна. | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төрийн үйлчилгээний техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх төслийн хүрээнд Соёлын яамнаас эрх шилжүүлсэн 300.0 сая төгрөгийн тендер зарлагдан худалдан авалт хийгдсэн. Энэхүү хөрөнгө оруулалтаар харьяа соёлын 7 байгууллагыг нийт 23 нэр төрлийн 97 ширхэг техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангасан. Үүнээс:<br>➢ Залуучууд театрт 14 нэр төрлийн 37 ширхэг 150.0 сая төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж;<br>➢ Төв номын санд 11 нэр төрлийн 12 ширхэг 25.4 сая төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж;<br>➢ Музейд 9 нэр төрлийн 10 ширхэг 25.4 сая төгрөгийн үнэ бүхий тоног тхөрөөмж;<br>➢ Хүүхдийн номын ордонд 8 нэр төрлийн 9 ширхэг 28.8 сая | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж;<br>➢ 3 сумдын соёлын төвд нийт 9 нэр төрлийн 29 ширхэг 67.3 сая төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн.<br><br>**Хүрсэн түвшин:**<br>Гүйцэтгэлээр санхүүжүүлсэн дүн нь 300.0 сая төгрөг болно. | |

ТАНИЛЦСАН:
ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА Б.АЗЖАРГАЛ

ТАЙЛАНГ ХЯНАСАН:
НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Н.ЦАСЧИХЭР

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:
НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН Л.БУЯНХИШИГ

**СОЁЛЫН САЙДААС ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ 2024 ОНД ЗАСГИЙН ГАЗРЫН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ ОРОН НУТАГТ ТӨЛӨӨЛӨН ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА**

2024.06.10

| № | Зорилт / Үнэлгээ | | Бүгд | Нэг. Соёлын салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, цахим шилжилтийг дэмжих чиглэлээр | Хоёр. Соёлын боловсролыг дээшлүүлэх чиглэлээр | Гурав. Урлаг, уран бүтээлийг хөгжүүлэх чиглэлээр | Дөрөв. Соёлын өвийг хадгалж, хамгаалах чиглэлээр | Тав. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр | Хавсралт 2 Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Хяналтанд авсан арга хэмжээний тоо | | **33** | 5 | 9 | 6 | 5 | 4 | 4 |
| 2. | Үнэлгээ, үүнээс | 100.0% | **26** | 5 | 7 | 5 | 3 | 3 | 3 |
| | | 90.0% | **3** | - | 1 | - | 1 | 1 | - |
| | | 70.0% | **4** | - | 1 | 1 | 1 | - | 1 |
| | | 50% | **-** | - | - | - | - | - | - |
| **Ерөнхий үнэлгээ** | | | **95.45% буюу 4.77 оноо** | **100% буюу 5.0 оноо** | **95.55% буюу 4.77 оноо** | **95.0% буюу 4.75 оноо** | **92.0% буюу 4.60 оноо** | **97.5% буюу 4.87 оноо** | **92.5% буюу 4.62 оноо** |

ТАНИЛЦСАН:
ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА Б.АЗЖАРГАЛ

ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА П.БАЯРСАЙХАН

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН О.МӨНХСҮРЭН